

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ХЭЛТСИЙН НӨХӨН ҮРЖИХҮЙ,
ХҮҮХЭД, ӨСВӨР ҮЕ, ЗАЛУУЧУУДЫН ЭРҮҮЛ МЭНД ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Б.ОРОЛЗОДМААГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин (эхний хагас жил)	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Нөхөн үржихүй, хүүхэд, өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн бодлого боловсруулах”							
1.	Арга хэмжээ 1.1 Гэр бүлийг дэмжих тухай хуулийг батлуулж хэрэгжүүлэх	Хуульд тусгуулсан заалтын тоо	0	Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөлд санал өгсөн байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас санаачлан боловсруулсан “Гэр бүлийг дэмжих тухай” анхдагч хуулийн төсөлд санал өгч 2025.06.02-ны өдөр Хуулийн хэлтсээс ирүүлсэн Дотоод меморандум №196 хариуг хүргүүлсэн. Үүнд: 1. Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн “Эрүүл мэндийг дэмжих” хэсгийн 11.1.3, 11.1.4, 11.1.5, 11.1.6, 11.1.7 заалтуудыг өөрчлөн найруулахаар; 2. Төслийн 11.1.8, 11.1.9, 11.1.10, 11.1.11 заалтуудыг шинээр нэмэхээр. Үүнд: ➤ Төсөлд 11.1.8 дахь заалт болгон “Жирэмсэн эх, 5 хүртэл насны хүүхдэд өгөх олон найрлагат бичил тэжээл, амин дэм, хоол тэжээлийн багц гарган сурталчлан таниулж, түгээх” хэмээн нэмж оруулах; ➤ Төсөлд 11.1.9 дэх заалт болгон “Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлд гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэн тэргүүнд хүргэх” хэмээн нэмж оруулах;	03.01 12.01	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин (эхний хагас жил)	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					➤ Төсөлд 11.1.10 дахь заалт болгон "Үргүйдэлтэй гэр бүлд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ойртуулж, нийгэм, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх" хэмээн нэмж оруулах; ➤ Төсөлд 11.1.11 дэх заалт болгон "Гэр бүлийг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх багцыг бий болгож эрүүл мэндийн даатгалын сантай уялдуулах" хэмээн нэмж оруулах;		
2.	Арга хэмжээ 1.2 "Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг 2025-2028 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулах	Эрүүл мэндийн сайдын батлагдсан тушаал	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаал	Арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулагдсан байна	Эрүүл мэндийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/465 дугаар тушаалаар "Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" 2025-2028 онд хэрэгжих арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, батлуулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн боловсруулсан арга хэмжээний төлөвлөгөөний төсөл дээр олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр зөвлөх авч ажиллуулан "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлэх талаар баримтлах бодлогыг нэгдүгээр, "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг 2025-2028 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/219 тоот тушаалаар батлуулсан.	01.01 10.01	100
3.	Дэд арга хэмжээ 1.2.1: Ажлын хэсгийн хурал зохион байгуулж,	Хурлын тоо, оролцогчдын тоо		Ажлын хэсгийн гишүүдийн дунд уулзалт, хэлэлцүүлэг	"Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" 2025-2028 онд хэрэгжих арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, батлуулах ажлын хэсэг 23 гишүүнтэй	01.01 05.30	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин (эхний хагас жил)	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	төлөвлөгөөний төсөл боловсруулах			зохион байгуулсан байна	бөгөөд ажлын хэсгийг 3 бүлэгт хуваан ажиллуулан, бүлгийн уулзалтыг тус бүр 3 удаа хийсэн. Үүнд: 1. Эх, нярайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ 2. Бага насны хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ 3. Өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гэсэн 3 бүлгээр ажилласан. Төлөвлөгөөний төслийг боловсруулж дуусаад ажлын хэсгийн гишүүдэд танилцуулан, санал авах хэлэлцүүлэг, уулзалтыг 2025.04.16-ны өдөр зохион байгуулсан. Ажлын хэсгийн хэлэлцүүлгээс гарсан саналыг төлөвлөгөөний төсөлд тусган оруулж боловсруулсан.		
					“Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” 2025-2028 онд хэрэгжих арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулах ажлын удирдамж Эрүүл мэндийн сайдаар 2025.04.07-ны өдөр батлуулсан.		
4.	Дэд арга хэмжээ 1.2.2: Төлөвлөгөөний төсөлд санал авах хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, төлөвлөгөөнд тусгах	Хэлэлцүүлэг, уулзалтын тоо, оролцогчдын тоо		2 удаагийн хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулсан байна	Арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд санал авах хэлэлцүүлэг, уулзалтыг 3 удаа зохион байгуулсан. Үүнд: 1. Арга хэмжээний төлөвлөгөөний төсөл танилцуулж санал авах хэлэлцүүлэг уулзалтыг 2025.04.29-ний өдөр ЭМДЕГ, ЭМХТ, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-II, НЭМҮТ, СЭМҮТ, ГССҮТ, АӨСҮТ, ХӨСҮТ, ХТС, Интермед эмнэлэг, Гурван гал нэгдсэн эмнэлэг, НЭМГ, амаржих газрууд, АШУҮИС, нийгэмлэг, холбоод, олон улсын байгууллагуудын төлөөлөл болох нийт 45 удирдах албан тушаалтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарыг оролцуулан	01.01 08.30	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин (эхний хагас жил)	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					зохион байгуулж, бүлгээр ажиллуулан санал авсан. Уг хэлэлцүүлэг, уулзалтад оролцох тухай албан бичгийг 2025.04.24-ний өдрийн 6/2013 тоот албан бичгээр эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. 2. "Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний 2021-2024 онд хэрэгжсэн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хийсэн төгсгөлийн үнэлгээ танилцуулах уулзалтыг 2025.01.28-ны өдөр зохион байгуулсан. Тус уулзалт, хэлэлцүүлэгт ЭМДЕГ, ЭМХТ, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-II, НЭМГ, амаржих газрууд, АШУҮИС, дүүргийн ЭМТ-үүдийн удирдлага болон холбогдох эмч, мэргэжилтэн нар болон олон улсын байгууллагын төлөөлөл, ажлын хэсгийн гишүүд болох нийт 50 хүн оролцсон. Уг үнэлгээнээс гарсан зөвлөмжийг арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусган оруулж боловсруулсан. Уг хэлэлцүүлэг, уулзалтад оролцох тухай албан бичгийг 2025.01.24-ний өдрийн 6/384 тоот албан бичгээр эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. 3. Төлөвлөгөөний төслийг 2025.04.17-ны өдөр танилцуулан Аймгийн ЭМГ-ын нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга, эх, хүүхэд болон хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, эх барих, эмэгтэйчүүдийн эмч, хүүхдийн эмч нар оролцуулсан хэлэлцүүлгийг 80 хүнд хийн, бүлгээр ажиллуулан санал авсан.		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин (эхний хагас жил)	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
5 (3)	Арга хэмжээ 1.3 “Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд” арга хэмжээг 2025-2028 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулах	Эрүүл мэндийн сайдын батлагдсан тушаал	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/559 дүгээр тушаал	Арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулагд аж эхэлсэн байна	“Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд” 2025-2028 онд хэрэгжих арга хэмжээний төлөвлөгөөг ажлын хэсэг 3 дэд хэсэгт хуваагдан ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар 4 зорилтын хүрээнд 38 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөний эхний драфт гараад байна.	01.10 12.30	100
6	Дэд арга хэмжээ 1.3.1: Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулах	Ажлын хэсэг байгуулсан тухай тушаал		Ажлын хэсэг байгуулагдан, 1 удаагийн хурал зохион байгуулсан байна	Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/65 дугаар тушаалаар “Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд” 2025-2028 онд хэрэгжих арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, батлуулах УНТЭ-УАТ, ЭХЭМҮТ, НЭМҮТ, СЭМҮТ, ЭМХТ, ХЗДХЯ, ЖҮХ, ТТАХЭ, ЦТЭ, ОУБ-уудын төлөөлөл болох нийт салбар дундын 18 хүнтэй ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийн хурлыг 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж 3 бүлэгт хуваан ажиллуулж байна. Үүнд: 1. Бодлогын бичиг, баримт боловсруулалт 2. Эрэгтэйчүүдийн эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ 3. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрдэм шинжилгээ, судалгаа	01.10 09.30	100
7	Дэд арга хэмжээ 1.3.2: Төлөвлөгөөний төсөлд санал авах хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, төлөвлөгөөнд тусгах	Хэлэлцүүлэг, уулзалтын тоо, оролцогчдын тоо			Хугацаа болоогүй	01.01 11.30	-

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин (эхний хагас жил)	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 2. “Нөхөн үржихүй, хүүхэд, өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах”							
8 (4)	Арга хэмжээ 2.1 “Гамшгийн үед иргэдэд үзүүлэх НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээг сайжруулах нь” сэдэвт үндэсний сургагч багш бэлдэх сургалт зохион байгуулах	Батлагдсан удирдамж, Хөтөлбөр, сургалтын тоо	Үндэсний 24 сургагч багш	Удирдамж, хөтөлбөр батлуулсан байна	“Гамшгийн үед иргэдэд үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах нь” сэдэвт үндэсний сургагч багш бэлдэх сургалтын удирдамж, хөтөлбөрийн төсөл боловсруулан, хянуулж байна.	02.01 12.01	30
9.	Арга хэмжээ 2.1.1 Сургалт явуулах бүс, нутаг болон сургагч багшаар ажиллах багш нарыг сонгож, бэлтгэл ажил хангагдсан байх	Сонгогдсон аймгийн тоо		Удирдамж, хөтөлбөр батлуулсан байна	“Гамшгийн үед иргэдэд үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах нь” сэдэвт үндэсний сургагч багш бэлдэх сургалтыг орон нутагт энэ оны III улиралд хийхээр төлөвлөсөн. <i>удирдамж, хөтөлбөр</i>	02.01 12.01	100
10. (5)	Арга хэмжээ 2.2 Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяныг зохион байгуулах	Батлагдсан удирдамж, хөтөлбөр	2024 онд үйл ажиллагаа зохион байгуулсан	-	Хугацаа болоогүй	09.01 12.01	-
11.	Арга хэмжээ 2.2.1 Үйл ажиллагаа зохион байгуулах салбар дундын уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байх	Хэлэлцүүлэг, уулзалтын тоо, оролцогчдын тоо		-	Хугацаа болоогүй	09.01 10.01	-

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин (эхний хагас жил)	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
12.	Арга хэмжээ 2.2.2 Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны нээлтийн үйл ажиллагааг бусад салбарын оролцоотой зохион байгуулж, үйл ажиллагаа эхэлсэн байх	Үйл ажиллагаа хийх тоо, оролцогчдын тоо		-	Хугацаа болоогүй	10.01 12.10	-
13.	Арга хэмжээ 2.3 Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах талаарх сургалт зохион байгуулах	Батлагдсан удирдамж, хөтөлбөр	2024 онд зохион байгуулсан сургалт	Удирдамж, хөтөлбөр батлуулсан байна	Эрүүл мэндийн сайдаар 2025.04.30-ны өдөр "Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцины болон умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэхэд эмч, мэргэжилтэн нарт сургалт зохион байгуулах" тухай ажлын удирдамж батлагдсан. Нийслэлийн хэмжээнд батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалт зохион батлуулсан. Үүнд: 1. "Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалт" сэдэвт сургалтыг нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн багш нарт 2. "Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтын харилцаа холбоо, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг шинжилгээг сайжруулах нь" сэдэвт сургалтыг нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэн нарт тус тус зохион байгуулахаар хөтөлбөр гаргасан.	01.01 12.01	100 ц

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин (эхний хагас жил)	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
14.	Арга хэмжээ 2.3.1 Сургалт зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж удирдамж, хөтөлбөр батлуулан эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэх	Батлагдсан удирдамж, Хөтөлбөр		Нийслэлд сургалтын үйл ажиллагаа эхлүүлсэн байна	Батлагдсан удирдамж, хөтөлбөрийн дагуу нийслэлийн хэмжээнд нийт 400 орчим ерөнхий боловсролын сургуулийн багш, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэн нарт сургалт зохион байгуулсан. Үүнд: 1. “Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалт” сэдэвт сургалтыг 2025.04.28-04.30-ны өдрүүдэд нийслэлийн ЕБС-ийн бага ангийн менежер, 5 дугаар ангийн багш нар болох нийт 320 хүнд сургалт зохион байгуулсан. 2. “Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтын харилцаа холбоо, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг шинжилгээг сайжруулах нь” сэдэвт сургалтыг 2025.05.27-05.28-ны өдрүүдэд нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа төрөлжсөн эрүүл мэндийн байгууллага, 9 дүүргийн ЭМТ, Нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн эмэгтэйчүүдийн эмнэлгийн эх барих, эмэгтэйчүүд болон өсвөр үеийн эмч нар болох нийт 80 орчим хүнд сургалт зохион байгуулсан.	02.01 06.01	100
15.	Арга хэмжээ 2.4 Эрэгтэйчүүд олноор суралцдаг салбарын цэрэг, сонсогчдын дунд эрүүл зан үйл, дадал хэвшлийг бий болгох	Уулзалтын тоо, оролцогчдын тоо	2024 онд зохион байгуулсан үйл ажиллагаа	Салбар дундын уулзалт зохион байгуулж, сургалт хийгдсэн байна	- ХЗДХЯ, БХЯ, ЖҮХ-ны удирдах албан тушаалтан, холбогдох эмч, мэргэжилтэн болох нийт 10 албан тушаалтантай 2025.03.04-ний өдөр уулзалт зохион байгуулж 03 дугаар сард хийх сургалтын санал солилцон, хөтөлбөр боловсруулсан.	02.01 12.01	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин (эхний хагас жил)	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах				- ХЗДХЯ-тай хамтран “Нөхөн үржихүйн эрүүл мэнд-Гэр бүл төлөвлөлт”, “БЗДХ/ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх” “Архи, тамхины хор уршиг, Залуусын сэтгэлзүйн эрүүл мэнд” сэдвүүдээр сургалтын хөтөлбөр гарган газрын даргаар батлуулж, МУ-ын Дотоод хэргийн их сургуулийн 500 оюутан, суралцагчдад 2025.03.13-ны өдөр сургалт зохион байгуулсан. - “Иргэдийг цэргийн жинхэнэ цэргийн албанд эрүүл мэндээр тэнцүүлэх үйл ажиллагаанд анхаарах нь” сэдэвт цахим хэлэлцүүлэгт 2025.05.01-ний өдөр оролцож аймаг, нийслэлийн ЭМГ, аймаг нийслэлийн цэрэг татлагын эмч нарын комисст ажиллах эмч нартай санл солилцсон.		
16.	Арга хэмжээ 2.5 Эх эмэгтэйчүүдийн барих, эмч нарт сургалт зохион байгуулах	Батлагдсан удирдамж, хөтөлбөр	Эрүүл мэндийн сайдын 2024 оны “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээн ий журам” А/292	Нийслэлд сургалт зохион байгуулсан байна	1. “Дутуу төрөлт: сэргийлэлт ба дутуу нярайн менежментийн шилдэг туршлага” сэдэвт олон улсын сургалтыг ДЭМБ, Ази, Номхон далайн Перинатологийн Нийгэмлэгүүдийн Холбоо, Монголын перинатологи нийгэмлэгтэй хамтран 2025.06 дугаар сарын 09-10 ны өдрүүдэд эх барих, эмэгтэйчүүд болон хүүхэд, нярайн нийт 200 гаруй эмч нар оролцон Б.Лхам-Эрдэнэ шинжээчийн хамт зохион байгуулсан. 2. Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын жирэмсний хяналт хариуцдаг эмч нарыг чадавхжуулах сургалтыг доорх агуулгын хүрээнд орохоор хөтөлбөр батлуулсан. Үүнд:	01.01 12.01	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин (эхний хагас жил)	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
			дугаар тушаал		➤ “Резус сөрөг цустай жирэмсэн эхийн жирэмслэлт, төрөлт” ➤ “Эх барихын үжил, халдвар. Орчин үеийн менежмент” ➤ “Жирэмсэн үеийн цус багадалт” ➤ “Нөхөн үржихүйн эрхтэн, тогтолцооны үрэвсэлт өвчний оношилгоо, эмчилгээний цогц менежмент” ➤ “Дутуу төрөлтөөс сэргийлэх менежмент” ➤ “Жирэмсэн үеийн чихрийн шижин” Сургалтыг 2025.06.25-ны өдөр Нийслэлийн ЭМГ, ЭНЭҮТ-II, Амаржих газрууд, дүүргийн ЭМТ, ӨЭМТ-үүдийн жирэмсний хяналт хариуцдаг 80 эмч оролцуулахаар зохион байгуулалтыг хангаад байна		
	Арга хэмжээ 2.5.1				1. Эрүүл мэндийн сайдаар “Дутуу төрөлт: сэргийлэлт ба дутуу нярайн менежментийн шилдэг туршлага” сэдэвт олон улсын сургалт, семинарын удирдамж 2025.05.05-ны өдөр батлагдан, сургалтын хөтөлбөр гарсан.	02.01 12.01	100
17.	Сургалт зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж удирдамж, хөтөлбөр батлуулан эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэх	Батлагдсан удирдамж, Хөтөлбөр		Удирдамж, хөтөлбөр батлуулсан байна	2. Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын жирэмсний хяналт хариуцдаг эмч нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулах хөтөлбөрийг 2025.06.12-ны өдөр ТНБД-аар батлуулсан.		
18.	Арга хэмжээ 2.6	Сургалтын тоо,	Эрүүл мэндийн сайдын	Нийслэлийн өсвөр үеийн эмч,	1. Эрүүл мэндийн сайдын “Журам шинэчлэн батлах тухай” А/504 дүгээр тушаалыг танилцуулах уулзалтын хөтөлбөрийг 2025.01.24-ний өдөр	01.20 06.01	100

9

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин (эхний хагас жил)	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	Эрүүл мэндийн сайдын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” (Өсвөр үеийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний журам) А/504 тоот тушаал болон холбогдох журам, зааврыг танилцуулах сургалт зохион байгуулах	оролцогчдын тоо	2017 оны А/399 дүгээр тушаал	мэргэжилтэнд сургалт зохион байгуулсан байна	батлуулан ЭМДЕГ, ЭМХТ, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-II, НЭМҮТ, СЭМҮТ, ХӨСҮТ, НЭМГ, Амаржих газрууд, Дүүргийн ЭМТ-үүд, ОУБ-уудын удирдах албан тушаалтан, эм, мэргэжилтэн болох нийт 60 хүн оролцсон сургалтыг танхимаар 2025.01.31-ний өдөр зохион байгуулсан. Сургалтад хамрагдах тухай албан тоотыг 2025.01.24-ний өдрийн 6/444 дүгээр албан бичгээр эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. 2. Аймгийн эрүүл мэндийн газрын дарга нарт сургалтад хамрагдах тухай албан тоотыг 2025.02.04-ний өдрийн 6/4632 дүгээр албан бичгээр хүргүүлэн Эрүүл мэндийн сайдын “Журам шинэчлэн батлах тухай” А/504 дүгээр тушаалыг танилцуулах уулзалтыг 2025.02.07-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Цахимаар 100 эмч, мэргэжилтэн хамрагдсан.		
19.	Арга хэмжээ 2.7 Гэр бүл төлөвлөлт буюу жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл, үр хөндөлтийн хор уршгийн талаар инфографик, контент боловсруулан түгээх	Инфографик, контентын тоо	-	2 инфографик, 2 рийл боловсруулж, түгээсэн байна	Азийн хөгжлийн банкны “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн хүрээнд 2025 онд “Гэр бүл төлөвлөлт, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт”-ийн талаар 3 пост, 6 рийл контент хийгдэн, цахимаар түгээгдэж эхлээд байна. Үүнд: Сошиал пост: 1. Гэр бүл төлөвлөлт пост 2. Жирэмснээс хамгаалах арга, хэрэгсэл пост 3. Үр хөндөлтийн хор уршиг пост	02.01 12.01	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин (эхний хагас жил)	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					Рийл: 1. Жирэмснээс хамгаалах арга, хэрэгсэл анимейшн рийл 2. Гэр бүл төлөвлөлт рийл ярилцлага 3. Суулгац Ярилцлага рийл 4. Ерөндөг ярилцлага рийл 5. Дааврын бэлдмэл ярилцлага рийл 6. Бэлгэвч ярилцлага рийл Холбоос, линк: Гэр бүл төлөвлөлт - Google Drive		
20.	Арга хэмжээ 2.8 Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/11 дүгээр тушаалаар батлуулсан "Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх, худалдан авах, зарцуулах, тайлагнах журам шинэчлэн батлах тухай" журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах	Уулзалт, хэлэлцүүлгийн тоо Судалгааны мэдээлэл	Хэрэгжилт 50%	Хэрэгжилт хангалтгүй байгаа ЭМБ-уудын судалгааг гаргах	Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/11 дүгээр тушаалаар батлуулсан "Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх, худалдан авах, зарцуулах, тайлагнах журам шинэчлэн батлах тухай" журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд "Гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний зохицуулалт, хариу арга хэмжээг бэхжүүлэх" талаар уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын удирдамжийг Эрүүл мэндийн сайдаар 2025.05.02-ны өдөр батлуулсан. Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм, эмнэлгийн хэрэгслийн тандалт мэдээллийн нэгдсэн санд шинэ модуль бүхий 5 хэсэгтэй цахим платформ үүсгэсэн ба уг мэдээллийн нэгдсэн санд одоогийн байдлаар доорх агуулгаар мэдээлэл орсон бөгөөд тушаалын хэрэгжилт Үүнд: ➤Хувь хүний талаарх мэдээллийг 21 аймаг, Улаанбаатар хотын 8 дүүрэг;	02.01 12.01	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин (эхний хагас жил)	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					➢ Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын мэдээллийг 20 аймаг, Улаанбаатар хотын 7 дүүрэг; ➢ Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгслийн тайланг 12 аймаг, 5 дүүрэг; ➢ Эм, эмнэлгийн хэрэгслийн тайланг 8 аймаг, 2 дүүрэг; ➢ Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн орлогын бүртгэлийг 18 аймаг, 6 дүүрэг ирүүлж, ЭМС-ын тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн ЭМБ-уудад уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.		
21. 12	Арга хэмжээ 2.9 “Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхам”-ын үйл ажиллагааг эрчимжүүлэх	Сургагч багшийн тоо	Сургагч багш - 30	Удирдамж, хөтөлбөр батлуулсан байна	Төрийн нарийн бичгийн даргаар 2025.05.08-ны өдөр “Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих арван алхам”-ын үндэсний сургагч багш бэлтгэх сургалтын удирдамж, сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг 2025.05.19-ний өдөр газрын даргаар батлуулсан. Сургалтын хөтөлбөр нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2020 онд гаргасан “Хүүхдэд ээлтэй эмнэлэг санаачилга (Baby-friendly hospital initiative)- Төрөх эмнэлгийн ажилтнуудад зориулсан сургалт”-ын гарын авлагын агуулгын хүрээнд боловсруулсан. Тус гарын авлага нь 4 багц модуль бүхий нийт 21 хичээлийн агуулга батгаасан 425 хуудас бүхий сургалтын хэрэглэгдэхүүн юм.	02.01 12.01	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин (эхний хагас жил)	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					1-р ээлжийн сургалт 2025.05.28-аас 05.30-ны хооронд зохион байгуулагдсан. Үүнд: Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод аймгийн эрүүл мэндийн газар, БГД, БЗД, ЧД-ийн эрүүл мэндийн төвийн нярайн эмч, эх баригч, сувилагч зэрэг нийт 27 үндэсний сургагч багш бэлтгэгдсэн. 2-р ээлжийн сургалт 2025.06.04-аас 05.06-ны хооронд зохион байгуулагдсан. Үүнд: Говь-Алтай, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн газар, СБД, СХД, ХУД-ийн эрүүл мэндийн төвийн нярайн эмч, эх баригч, сувилагч зэрэг нийт 25 үндэсний сургагч багш бэлтгэгдсэн.		

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа	Хариуцасан ажлын хүрээнд хийгдсэн үйл ажиллагаа байна	2024 оны үйл ажиллагаа	Хариуцасан ажлын хүрээнд хийгдсэн үйл ажиллагаа биелэлт хэрэгжсэн байна	1. Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороонд 2025 оны 03 дугаар сар хүртэл нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэх хугацаанд: ➤ Ёс зүйн дэд хорооны хурлыг нийт 4 удаа хуралдуулж, 3 асуудлыг хэлэлцүүлэн, шийдвэрлүүлсэн. ➤ Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороонд 2024 оны үйл ажиллагааны тайлан, хүснэгтэн тайлан нэгтгэн 2025.01.27-ны өдөр Ёс зүйн хороонд хүргүүлсэн.	01.01 12.01	100

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
	1	2	3	4	5	6	7
					➤ Албан бичиг боловсруулалт: НЭМГ-т өргөдөл шилжүүлэх тухай 2025.01.03-ны өдрийн 10/43 албан тоот, ЭМЯ-ны ТНБД-д 2025.01.06-ны өдрийн 10/69 албан тоот, Авилагатай тэмцэх газарт мэдээлэл хүргүүлэх тухай 2025.01.06-ны өдрийн 02/85 албан тоот, Ёс зүйн хороонд албан бичгийн хариу хүргүүлэх тухай 2025.01.22-ны өдрийн 02/359 албан тоот, Эрүүл мэндийн сайдад Ёс зүйн дэд хорооны дүгнэлт хүргүүлэх тухай 2025.02.11-ний өдрийн 10/776 албан тоот, Өмнөговь аймгийн БОЭТ-ийн захиралд Ёс зүйн дэд хорооны дүгнэлт хүргүүлэх тухай 2025.02.11-ний өдрийн 10/777 албан тоот, Монфа Трейд ХХК-д Ёс зүйн дэд хорооны дүгнэлт хүргүүлэх тухай 2025.02.11-ний өдрийн 10/778 албан тоот, ТАЗ, АТГ, ХЭҮК-т мэдээлэл хүргүүлэх тухай 2025.02.14-ний өдрийн 10/855 албан тоот, НЭМҮТ-ийн захиралд дүгнэлт хүргүүлэх тухай 2025.02.14-ний өдрийн 10/856 албан тоот, НЭМҮТ-д зөвлөмж хүргүүлэх тухай 2025.02.14-ний өдрийн 10/857 албан тоотыг тус тус боловсруулан явуулсан. 2. “Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд бидний оролцоо” сэдэвт нөлөөллийн аянг яамны харьяа эрүүл мэндийн байгууллагуудын удирдах албан тушаалтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажиллагсдын дунд зохион байгуулах удирдамж боловсруулан Ёс зүйн дэд хорооны даргаар 2025.06.11-ний батлуулан, харьяа ЭМБ-уудад 2025.06.13-ны өдрийн 3/3081 тоо албан бичиг хүргүүлсэн.		

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
	1	2	3	4	5	6	7
2.	Осол гэмтэл, хүчирхийлэл, жендэрийн асуудлын хүрээнд	Орлон ажиллах хугацаанд хийгдсэн үйл ажиллагаа байна	-	Орлон ажиллах хугацаанд хийгдсэн үйл ажиллагаа биелэлт хэрэгжсэн байна	Осол гэмтэл, хүчирхийлэл, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байрыг 2024.02.01 – 07.15 хүртэл орлон ажиллаж байх хугацаанд: 1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Зам тээврийн яам, Аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран хүн амыг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад салбар бүрийн оролцоог хангах, үйл ажиллагааг уялдуулах, аюулгүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлыг хамтран зохион байгуулах зорилгоор 2025.11 сар хүртэл аян зохион байгуулаад байна. 2. Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Ж.Хунанд доорхи мэдээллийг боловсруулан, бэлтгэж хүргүүлсэн. Үүнд: ➤ Мориноос унаж гэмтсэний улмаас Гэмтэл согог судлалын үндэсний төвд яаралтай тусламж авсан 0-18 насны хүүхдийн мэдээлэл (2006-2015 он) ➤ Улсын хэмжээнд бүртгэгдсэн мориноос унаж гэмтсэн 0-18 насны хүүхдийн мэдээлэл (2016-2024 он) ➤ Мориноос унаж гэмтсэний улмаас Гэмтэл согог судлалын үндэсний төвд хэвтэн эмчлүүлсэн болон мэс заслын тусламж авсан 0-18 насны хүүхдийн мэдээлэл (2006-2024 он) 3. Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэд доорхи мэдээллийг боловсруулан, бэлтгэж хүргүүлсэн. Үүнд: ➤ Насанд хүрээгүй хүүхдийн амиа хорлолтын тоо, нас, хүйсээр ангилсан мэдээ (2020-2024 он);	02.01 07.15	100

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
	1	2	3	4	5	6	7
					➤ Насанд хүрээгүй хүүхдийн согтууруулах ундаа мансууруулах бодисын хэрэглээ, донтолттой холбоотой бүртгэгдсэн тоо, мэдээлэл (2020-2024 он) ➤ Насанд хүрээгүй хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл (2019-2023 он); ➤ Гэмтэл согог судлалын үндэсний төв болон Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн тандалтын албанаас гаргасан холбогдох тайлан, судалгааны материал; - Улсын хэмжээнд бүртгэгдсэн мориноос унаж гэмтсэн 0-18 насны хүүхдийн мэдээлэл (2016-2024 он) - Өсвөр үеийн эрүүл мэнд – Жирэмслэлт, хүчирхийлэлтэй холбоотой тоо, мэдээлэл (2019-2023 он) ➤ “Өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн зан үйлийн судалгаа” – 2024 он. 4. Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх хамгааллын 2024-2026 оны арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг гаргасан.		

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 2.1.	Сургалтад хамрагдсан байх	1 сургалтад хамрагдсан	Богино хугацааны сургалтад	1. “Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтын дархлаажуулалтын	01.01 12.01	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	Ажил үүрэгтэй холбоотой мэдлэг, мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтад хамрагдах			хамрагдсан байна.	хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх, эмч, багш, олон нийтэд чиглэсэн сургагч багш бэлтгэх” олон улсын аргачлалаар зохион байгуулсан сургалтад 2025.05.01-ны өдөр хамрагдан сургагч багшаар бэлтгэгдсэн гэрчилгээтэй болсон. 2. БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Улаан загалмайн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд Хөх хотод зохион байгуулагдсан “Анхны тусламжийн сургагч бэлтгэх” сургалт 2025.05.10-05.18-ны өдрүүдэд хамрагдан сургагч багшаар бэлтгэгдсэн гэрчилгээтэй болсон.		
	Арга хэмжээ 2.2.				1. Удирдлагын академиас зохион байгуулагдсан “Ёс зүйн дэд хороодын гишүүдийг чадавхжуулах” сэдэвт сургалтын хүрээнд нийт 16 цагийн хичээлд 2025.03.11-03.12-ны өдрүүдэд хамрагдан №Z0517 үнэмлэхтэй төгссөн. 2. Ёс зүйн хороо, Удирдлагын академи хамтран зохион байгуулсан “Ёс зүйн сургагч багш бэлтгэх” сургалтад 2025.05.18-05.23-ны өдрүүдэд хамрагдан №Z1442 үнэмлэхтэй төгссөн.		
2.	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээтэй холбоотой сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байх	1 сургалтад хамрагдсан	Богино хугацааны сургалтад хамрагдсан байна.		03.01 12.01	100

ТАЙЛАН ГАРГАСАН:
Нөхөн үржихүй, хүүхэд, өсвөр
үе, залуучуудын эрүүл мэнд
хариуцсан мэргэжилтэн

Б.Оролзодмаа /  /

2025.06.10